

**БНСУ-д удаан хугацаанд оршин сууж буй гадаадын харьяат хүүхдийн сурах эрхийг хамгаалах зорилгоор оршин суух эрх олгох тухай**

- БНСУ-д хууль бусаар сургуульд сурч буй гадаадын харьяат хүүхдүүд болон түүний эцэг, эхэд оршин суух эрх олгох үед дараахь нөхцлийг бүрэн хангасан байна.

Бүртгүүлэх хугацаа болон хамрагдах нөхцөл

(Бүртгүүлэх хугацаа) 2022. 02. 01. ~ 2025. 03. 31. (Хэрэгжих хугацаа)

(Хамрагдах хүүхэд) Өргөдөл гаргах үед дараахь ① эсвэл ② нөхцлийг аль нэгийг нь бүрэн хангасан байх.

① ▲БНСУ-д төрсөн эсвэл 6-аас доош насандаа тус улсын хилээр орж ирсэн ▲БНСУ-д 6-аас дээш жил оршин суусан ▲Өргөдөл гаргах үед БНСУ-д бага, дунд, ахлах сургуульд суралцаж байх эсвэл төгссөн

② ▲БНСУ-д хилээр 6-аас дээш насандаа орж ирсэн ▲БНСУ-д 7-оос дээш жил оршин суусан ▲Өргөдөл гаргах үед БНСУ-д бага, дунд, ахлах сургуульд суралцаж байх эсвэл төгссөн

Оршин суух эрх олгох үйл ажиллагаа

(хүүхэд)

① (Өргөдөл гаргах үед бага, дунд болон ахлах сургуульд суралцаж байгаа тохиолдолд) Ахлах сургууль төгсөх хүртэл хугацаанд суралцах (D-4) ангилалын оршин суух эрх олгоно.

② (Өргөдөл гаргах үед ахлах сургуулиа төгссөн тохиолдолд) ▲Суралцах, ажиллах нөхцлийг

хангаж байгаа тохиолдолд тухайн нөхцөлд нийцсэн оршин суух эрхийг өөрчлөн олгоно. ▲ Суралцах болон ажиллах нөхцлийг хангаагүй тохиолдолд 1 жилийн түр хугацааны оршин суух (G-1) ангилалын оршин суух эрх олгон өөрчлөх.

**(ЭЦЭГ, ЭХ)** Эцэг эх нь торгуулиа төлсөн тохиолдолд хүүхдийг ахлах сургуулиа төгсөх болон насанд хүрэх хүртэл хугацаанд (G-1) ангилалын оршин суух эрх олгох, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх зорилготой бол дээр дурдсан оршин суух ангилалаас гадуур хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох арга хэмжээг авна.

- **(Торгууль ногдуулах)** Хүүхдийн оршин суух зөвшөөрөл хүссэн эцэг эхийг хууль бусаар оршин сууж байгаа үеийн зөрчилд торгууль ногдуулах. \*

\* Торгууль төлөх чадваргүй, түүнтэй холбоотой шалтгаан байгаа тохиолдолд торгуулийн хэмжээг бууруулах арга хэмжээ авна.

**Өргөдөл гаргахтай холбоотой бичиг баримтын мэдээллийг:**

**(Бүрдүлэх бичиг баримт)** БНСУ-ын Хууль зүйн яамны харьяа Цагаачлалын албаны бодлогын хэлтэс([www.immigration.go.kr](http://www.immigration.go.kr)) болон([www.hikorea.go.kr](http://www.hikorea.go.kr)) сайтнуудаас мэдээлэл авч болно.

**(Өргөдөл гаргах)** Өргөдөл хүсэлтээ оршин суугаа газрын харьяа Цагаачлалын албанд гаргана. Хууль зүйн яамны харьяа Гадаадын иргэдийн нэгдсэн зөвлөгөө өгөх төв(Утасны дугаар 1345, орчуулгийн үйлчилгээ үзүүлнэ. )

※ Ажлын цагийн хуваарь 09:00~22:00(Бямба, ням, бүх нийтийн амралтын өдрүүдэд амрана.), 18 цагаас хойш солонгос, англи, хятад хэлээр зөвлөгөө авч болно.